

БАТЛАВ:
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД Х.БАДЕЛХАН

**БАРИЛГЫН САЛБАРЫН 2019-2020 ОНЫ ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гүйцэтгэх ажлын нэр	Хугацаа (он, сар)	Хариуцах байгууллага, нэгж
Салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар			
1	"ILO" Олон улсын хөдөлмөрийн байгууллагын барилгын үйлдвэрлэлийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 167 дугаар конвенци болон 175 дугаар зөвлөмжийг УИХ-аар батлуулж, конвенцид нэгдэн орох асуудлыг шийдвэрлүүлнэ.	2019.XII сар	ББМУБХЗГ, МБНХ, МБҮЭХ
2	Барилгын тухай хууль, дагалдан гарсан дүрэм, журмуудын хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийнэ.	2019.XII сар	ББМУБХЗГ, ТЗУГ, ХШУДАГ, МБНХ
3	Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийг эхлүүлнэ.	2019.VII сар	ББМУБХЗГ, БХТ
4	Барилгын салбарын норм, нормативын баримт бичгийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх талаар хийгдсэн ажлуудад дүн шинжилгээ хийж ОХУ-ын Эрхүү мужийн барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй, орон сууцны чиглэлийн стандарт, норм, нормативыг судлан өөрийн орны нөхцөлтэй уялдуулан шинэчлэх ажлыг зохион байгуулна.	2019-2020 он	БТГ, ББМУБХЗГ, ХБГХБХЗГ, НААБХЗГ, БХТ, МБНХ
5	"150 мянган айл-орон сууц" үндэсний хөтөлбөр, "Түрээсийн орон сууц" зэрэг хөтөлбөр тэслүүдийг хэрэгжүүлэхэд барилгын салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагууд, мэргэжилтэй ажилчдын оролцоог нэмэгдүүлэх чадавхийг дээшлүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	2019-2020 он	ББМУБХЗГ, НААБХЗГ, ТЗУГ, МБНХ
6	Нийслэл болон аймаг, орон нутгийн хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжуудыг паспортжуулах, буулгаж шинээр барих болон гэр хорооллын бүсэд шинээр баригдах орон сууцны хорооллуудын дэд бүтэц, инженерийн хангамжийн шийдлүүдийг	2019-2020 он	ББМУБХЗГ, ХБГХБХЗГ, ИДББХЗГ, МБНХ

	тодорхойлсон төслүүдийг боловсруулж үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллана.		
7	Барилга байгууламжийн өөрийн өртгийг бууруулах, барилгын үйлдвэрлэлийн хугацааг уртасгах, улиралын нөлөөллийг багасгах, барилгын жинг хөнгөрүүлэх, дулаан алдагдлыг бууруулах сайжруулахад чиглэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.	2019-2020 он	ББМҮБХЗГ, МБМҮХ
8	Салбарын төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох чиглэлээр хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллана.	2020.II сар	БТГ, ТЗУГ, МБНХ, МБҮЭХ
Хөдөлмөр эрхлэлтийн талаар			
1	"Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-үүдийг салбарын хэмжээнд талуудын оролцоотойгоор хэрэгжүүлнэ.	2 жилийн Турш	ТЗУГ, МБНХ, МБҮЭХ
2	"Барилга, хот байгуулалтын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого"(2018-2025)-ыг талууд хамтран хэрэгжүүлж, жендэрийн мэдрэмжтэй ажлын байрыг бий болгоно.	2 жилийн турш	ТЗУГ, МБНХ, МБҮЭХ
3	Барилгын салбар дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаарх судалгаа, мэдээллийг бүрдүүлж, цаашид авах арга хэмжээг тодорхойлно.	2020.III сар	ТЗУГ, ББМҮБХЗГ, БХТ, МБНХ, МБҮЭХ
4	Барилгын салбарын ажиллах хүч, мэргэжилтний мэдээллийн санг бүрдүүлж, хөтлөх ажлыг зохион байгуулна.	2019-2020 оны	ТЗУГ, ББМҮБХЗГ, БХТ, МБНХ, МБҮЭХ
5	Барилгын салбарт ажиллагсадыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах ажлыг судалж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	2019-2020 он	ББМҮБХЗГ, МБНХ, МБҮЭХ
6	Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт /Yamat-2008/ болон тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох ажил мэргэжлийн жагсаалтанд барилгын салбарын ажил мэргэжлээр нэмэлт өөрчлөлт оруулж, хүрсэн түвшингээс бууруулахгүйгээр шинэчлэн батлуулахад төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.	2019.XII сар	ТЗУГ, ББМҮБХЗГ, МБНХ, МБҮЭХ
7	Салбарын хөдөлмөрийн норм, нормативыг шинэчилнэ.	2019-2020 он	ББМҮБХЗГ, БХТ
8	Барилгын ажлын гүйцэтгэгч нь Барилгын тухай хуулийн 40.1.9-т заасны дагуу барилга байгууламжийн суурь, хана, хучилт, шат, араг бүтээц, дээврийн ажлуудыг өөрийн ажилтнаар буюу хөдөлмөрийн гэрээ бүхий ажилтнаар гүйцэтгүүлж ажиллах зохицуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагуудад мөрдүүлнэ.	2019-2020 он	ББМҮБХЗГ, МБНХ, МБҮЭХ
9	Мэргэжилтэй ажилчдын ажлын байрны дадлагажуулах үйл ажиллагааг Мэргэжлийн Боловсрол сургалтын Үндэсний зөвлөлийн харъяа Барилгын	2019-2020 он	ТЗУГ, МБНХ, МБҮЭХ


	салбар зөвлөлтэй хамтран "Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан"-г барилгын салбарт зохион байгуулах ажлыг дэмжиж ажиллана.		
10	Их, дээд сургууль, коллеж төгссөн, МСҮТ, түр сургалтаар_ мэргэжил эзэмшсэн иргэнийг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр дагалдангаар ажиллуулах тохиолдолд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүйгээр цалин хөлс олгох тогтолцоог судалж, нэвтрүүлнэ.	2019-2020 он	ББМУБХЗГ, МБНХ, МБУЭХ
11	Барилгын салбарын ажилчдыг өндөр хөгжилтэй орнуудад гэрээгээр ажиллуулах, дадлагажуулахад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллана.	2019-2020 он	БТГ, ББМУБХЗГ, МБНХ
Цалин хөлсний талаар			
1	Барилгын салбарт ажиллагсдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 554064 /таван зуун тавин дөрвөн мянга жаран дөрвөн/ төгрөгөөс багагүй байлгах арга хэмжээг Монгол Улсын Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийг барилгын салбарын хэмжээнд мөрдлөг болгон ажиллана.	2019-2020 он	ББМУБХЗГ, МБНХ, МБУЭХ
2	Барилга байгууламжийн төсөвт өртөгт тусгагдсан ажилчдын цалингийн эх үүсвэр 2010 оноос өссөн болон барилгын материалын үнийн нэмэгдэл, бензин шатахуун болон төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбогдуулан барилгын "Тарифт цалингийн жишиг шинэчлэн батлах тухай" Барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 263 дугаар тушаалыг шинэчлэн баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	2019-2020 он	ББМУБХЗГ, БХТ, МБУЭХ
3	Барилгын салбарт ажиллагсадын хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн байдалд талууд хамтарсан үзлэгийг 2019-2020 онд хийж, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг авна.	2019-2020 он	ББМУБХЗГ, БХТ, МБНХ, МБУЭХ
4	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа барилгын салбарын цалингийн тарифын шинэчлэлийг барилгын суурь нормд нийцүүлэн хэрэгжүүлэх талаар судалж, санал боловсруулна.	2019.XII сар	ББМУБХЗГ, БХТ
5	Барилгын салбарт ажиллагсадын хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний байдалд МХЕГ болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран үзлэг зохион байгуулж, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажиллана.	2019-2020 он	ББМУБХЗГ, БХТ, МБНХ, МБУЭХ
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар			
1	"Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үндэсний зөвлөгөөн"-ийг жил бүр зохион байгуулна.	2019.V, 2020.V сар	ББМУБХЗГ, МБНХ, МБУЭХ

2	"Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам"-ыг хэрэгжүүлнэ.	2 жилийн турш	ББМҮБХЗГ, МБНХ, МБҮЭХ
3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр гарган хэрэгжүүлж, тайлант хугацаанд хийгдсэн ажлыг хэлэлцүүлж хэрэгжүүлнэ.	2019-2020 он	ББМҮБХЗГ, МБНХ
4	Барилгын салбарын мэргэжилтэй ажилчдын Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах бүртгэлжүүлэх, нэгдсэн мэдээлэлийн санг бий болгоход онцгой үүрэг гүйцэтгэх "Мэргэжилтэй ажилчны ХАБЭА-н хяналтын карт" төслийг салбарын хэмжээнд боловсруулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.	2019-2020 он	ББМҮБХЗГ, МБНХ, МБҮЭХ
5	Японы ЖАЙКА байгууллагатай хамтран "Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийн үйл ажиллагааг үр дүнтэй ажиллуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.	2019-2020 он	ББМҮБХЗГ, МБНХ
6	Барилгын салбарын инженер, техникийн ажилтнууд болон ажил олгогчдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад тогтмол хамруулах ажлыг зохион байгуулна.	2 жилийн турш	ББМҮБХЗГ, МБНХ, МБҮЭХ
7	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудын нэгдсэн өдөрлөг, хэлэлцүүлэг зохион байгуулна.	2019-2020 он	ББМҮБХЗГ, МБНХ, МБҮЭХ
8	Барилга байгууламжийн угсралтын ажлын явцад хөдөлмөрийн аюулгүй байдлын хууль, эрх зүйн баримт бичиг болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартуудын хэрэгжилтэд үзлэг хийж, мөрдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	2 жилийн турш	ББМҮБХЗГ, МБНХ, МБҮЭХ
9	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний 5 дахь хөтөлбөрийн хэрэгжилт болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулж ажиллана.	2019-2020 он	ББМҮБХЗГ, МБНХ, МБҮЭХ
10	2019 оныг "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны соёлыг ажлын байранд хэвшүүлэн, ажил олгогч, инженер, техникийн болон ажиллагсадын оролцоог нэмэгдүүлэн хэвшүүлэх" жил болгон зарлах ажлыг зохион байгуулна.	2019.V сар	ББМҮБХЗГ, МБНХ, МБҮЭХ
11	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг хангаж ажилласан барилгын салбарын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийг шалгаруулан алдаршуулж, Барилгачдын талбайд тугийг залах ажлыг зохион байгуулна.	2019.IX, 2020.IX сар	ББМҮБХЗГ, МБНХ, МБҮЭХ

12	ХАБЭА-н талаар үндэсний 5 дахь хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд салбарын ХАБЭА-н талаар сурталчилгаа хийж, ном, гарын авлага бэлтгэж гаргана.	2019.XII сар	ББМУБХЗГ
13	Барилгын салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн цахим сургалтын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.	2019-2020 он	ББМУБХЗГ, МБНХ
Нийгмийн түншлэлийн талаар			
1	Барилгын салбарын шийдвэрлэвэл зохих асуудлаар талууд харилцан зөвлөлдөх, мэдээлэл солилцох, хамтын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана.	2019-2020 он	ББМУБХЗГ, МБНХ, МБУЭХ
2	Барилгын салбарын төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд тулгамдсан асуудлуудыг хууль, эрх зүйн орчныг нь шинэчлэх замаар шийдвэрлэж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хамтын ажиллагааг дэмжинэ.	2019-2020 он	ТЗУГ, ББМУБХЗГ, МБНХ, МБУЭХ
3	Монгол Улсын ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолтод барилгын салбарын ажил, мэргэжлийн ангилал, албан тушаалын тодорхойлолтыг шинэчилэн сруулна.	2019.XII сар	ТЗУГ, МБНХ, МБУЭХ
4	Ипотекийн зээлийн хүрээнд хямд өртөгтэй орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх асуудлыг эдийн засаг, санхүүгийн бодлоготой уялдуулж хэрэгжүүлнэ.	2019-2020 он	БТГ, МБНХ

ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ:

Барилга, хот байгуулалтын
дэд сайд



Б.МӨНХБААТАР

Монголын барилгачдын нэгдсэн
холбооны ерөнхийлөгч



М.БАТБААТАР

Монголын барилгачдын үйлдвэрчний
эвлэлүүдийн холбооны дарга



Б.БАТЦОГТ